



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2023 БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛ

11
АНГИ

ГАЗАР ЗҮЙ

ХУВИЛБАР А

Аймаг / дүүрэг:

Сум / сургууль:

Анги / бүлэг:

Сурагчийн овог:

Сурагчийн нэр:


Сурагчийн код:

САНАМЖ

- Даалгаврыг 40 минутад гүйцэтгээрэй.
- Даалгавар тус бүрээс зөвхөн нэг хариултын хувилбарыг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу харандаагаар будаарай.


НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: СОНГОХ ДААЛГАВАР

1. Замын-Үүдийн боомтоор 2022 онд орж ирсэн хүний тоо 2020 оныхоос хэдээр буурсан байна вэ?



- A. 133064 B. 137823 C. 93419 D. 7805

2. 2013 ба 2023 оны хооронд тухайн хэсгийн хотын газар ашиглалтад гарсан өөрчлөлтийг тодорхойлоорой.




2013 онд

2023 онд

- A. 2013 оноос хойш хүн амын нягтшил багсаж, хотжилтын түвшин буурсан.
 B. 2013 оноос хойш барилга байгууламж устаж, хотжилт удааширсан.
 C. 2013-2023 он хүртэл орон сууц, барилга байгууламж бүхий хороолол нэмэгдсэн.
 D. 2013 – 2023 онд орон сууц нэмэгдэж, үйлдвэрлэл үйлчилгээ зогссон.

3. Хөгжлөөр тэргүүлэгч улс орнуудыг үзүүлэлтийг ажиглан боловсролын түвшнээр хамгийн өндөр улсыг сонгоорой.




A. Ирланд

B. Исланд

C. Австрали

D. Герман

4. Хөгжингүй орнуудын “Орлогын өөрчлөлт ба аз жаргалын индекс”-ийг харуулсан графیکیг зөв тайлбарласан хариултыг сонгоно уу.



- A. Хүн амын орлого ба аз жаргалын индекс буурсан.
- B. Хүн амын орлого өсөж, аз жаргалын индекс буурсан.
- C. Хүн амын орлого ба аз жаргалын индекс өссөн.
- D. Хүн амын орлого өсөж, аз жаргалын индекс тогтмол.


5. Чөлөөт худалдаа, хөрөнгө оруулалт, үйлдвэрийн бараа бүтээгдэхүүний олон улсын стандартчилал, тоо бүртгэл, олон улсын мөнгөн шилжүүлэг зэргийг эдийн засгийн даяаршил гэнэ. Эдийн засгийн даяаршлын хүрээнд хамаарахыг сонгоорой.



A.



B.




C.



D.


6. Дангаарчлалын үзэл санааг илэрхийлсэн үйл явцыг сонгоорой.
- A. Монгол улс нь 1964 оноос эхлэн Олимпын наадамд оролцож эхлэсэн бөгөөд үүнээс хойш бараг бүхий л зуны олимпод оролцсоор ирсэн.
 - B. Монгол наадам нь хүчит бөх, хурдан морь, сур болон шагайн харваа төдийгүй язгуур урлаг, дуу хуур, хөгжим бүжиг зэрэг ёслол хүндэтгэлтэй болдог.
 - C. Монгол улс нь ASEM-ийн дээд хэмжээний 11 дэх удаагийн уулзалтыг 2016 онд эх орондоо амжилттай зохион байгуулсан.
 - D. Монгол улс 2003 оны 12 дугаар сард олон улсын GS1 байгууллагын 101 дэх гишүүнээр элсэж бараа бүтээгдэхүүний “865” бүхий кодтой болсон.

7. Дэлхийн улс орнуудын хүн амын өсөлтийн хувийг тив тус бүрээр харуулав. 2010-2050 оны хооронд хүн амын өсөлт хамгийн их байх тивийг сонгоно уу.



- A. Ази
- B. Латин америк
- C. Африк
- D. Далайн орнууд

8. Төрөлт буурч, нас баралтын түвшин тогтвортой байх бөгөөд ердийн өсөлт буурч дундаж наслалт уртсах нь хүн ам зүйн шилжилтийн хэддүгээр үе шатад хамаарах вэ?



- A. V үе шат
- B. IV үе шат
- C. III үе шат
- D. II үе шат

9. Хүн ам нь гол төлөв нэг хэлтэй, нэг үндэстнээс бүрэлдэн тогтсон Европын улсыг сонгоорой.

- A. Япон
- B. Герман
- C. Бразил
- D. Бангладеш

10. Өмнөд Суданд болсон хүн амын дүрвэлт, шилжилт хөдөлгөөнд нөлөөлсөн НИЙГМИЙН хүчин зүйлийг сонгоорой.

- A. Үерийн давтамж нэмэгдсэн
- B. Нялхсын эндэгдэл ихэссэн
- C. Хөрсний үржил шим муудсан
- D. Хүнсний үйлдвэрлэл буурсан

11. Зурагт хүн амын ямар шилжилт хөдөлгөөн явагдаж байна вэ?




- A. Сайн дурын – Эдийн засгийн
- B. Албадлагын – Ажил хийх
- C. Сайн дурын – Түр зуурын
- D. Албадлагын – Байгалийн гамшгийн

12. Буддын шашны тархалтыг газар зүйн зурагт дүрслэн харуулав. Буддын шашин аль улсаас гаралтай байна вэ?



- A. Энэтхэг
- B. Төвөд
- C. БНХАУ
- D. Монгол

13. Зургийг ашиглан зөв тодорхойлолтыг сонгоорой.



- A. 2000 оноос 2010 онд бүх улс орнуудын хотжилтын түвшин нэмэгдсэн байна.
- B. Зөвхөн БНХАУ-ын хотжилтын түвшин өмнөх оноосоо нэмэгдсэн байна.
- C. Монгол улсын хотжилтын түвшин тогтвортой хэвээрээ байна.
- D. Мянмар улсын хотжилтын түвшин өмнөх оноосоо буурсан байна.


14. Улаан буудайг тариалахад нөлөөлөх **байгалийн** хүчин зүйлийг сонгоорой.
- Машин, механизм, техник хэрэгслийн нөөц
 - Тэгш гадарга, хар шороон ялзмаг ихтэй хөрсний нөөц
 - Мэргэжлийн ур чадвартай ажиллах хүчний нөөц
 - Хураах агуулах, тээвэрлэлтийн хэрэгслийн нөөц
15. Газар тариаланг худалдааны болон өрхийн зориулалтаар ашигладаг. Худалдааны зориулалттай газар тариалан эрхлэхийн давуу талыг сонгоорой.
- Ажиллах хүч нь гэр бүлийн хамтын хөдөлмөр, уламжлалт аргаар эрхэлдэг
 - Хортон шавжийн хор бага ашиглаж, өтөг бууц зэргийг ашигладаг.
 - Ихэнх үйл ажиллагаа нь машин, техник багаж төхөөрөмжөөр хийдэг.
 - Бага талбайд уламжлалт аргаар усжуулалтын системийг ашигладаг.
16. Аж үйлдвэрийн байршилд нөлөөлөх хүчин зүйлийг байгалийн болон нийгмийн гэж хоёр ангилдаг. Дараах үзүүлэлтээс байгалийн хүчин зүйлд хамаарах нь аль вэ?
- ажиллах хүч
 - зах зээл
 - хөрөнгө (мөнгө)
 - түүхий эд
17. Зургаас Монгол улсын аж үйлдвэрлэлийн салбарын үзүүлэлтийг ажиглан зөв тодорхойлолтыг сонгоно уу.



- Боловсруулах аж үйлдвэр хамгийн их үйлдвэрлэл явуулж байгаа нь хүрээлэн буй орчны бохирдолд хамгийн их нөлөөтэй.
 - Олборлох аж үйлдвэр боловсруулахаас тогтмол өндөр байгаа нь байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө хамгийн их.
 - Олборлох болон боловсруулах аж үйлдвэр хоёул ижил түвшинд байгаа нь хүрээлэн буй орчинд маш их сөргөөр нөлөөлнө.
 - Боловсруулах аж үйлдвэрийн үйл ажиллагаа нь тогтвортой явагдаж байгаа учир байгаль орчны бохирдолд маш бага нөлөө үзүүлнэ.
18. Улс орны **тогтвортой хөгжлийг** хангахад зориулагдсан “ЭКО аялал жуулчлал”-ын хөтөлбөрийг сонгоно уу.
- Загасчлах аялал – Өвөл голын усанд цооног үүсгэн загас барих
 - Спорт аялал – Өндөр уул, хадтай газар спорт машинаар уралдах
 - Явган аялал – Жимс, жимсгэний тариан талбайтай танилцах
 - Ангийн аялал – Ховордсон ан амьтдыг агнаж, чихмэл хийх

19. Сүүлийн таван жилийн дотор Гялсбанкны хэрэглэгчийн тоо 73%-иар, Гялсбанкаар хийж буй гүйлгээний тоо 97%-иар өссөн. Цахим банкны үйлчилгээний өсөлтөд нөлөөлсөн эерэг хүчин зүйлийг тайлбарлаарай.

Төрийн банкны Гялсбанк үйлчилгээний өсөлт



Эх сурвалж: Төрийн банк

- A. Хүн бүр хүссэн газраасаа үйлчилгээ авахад хялбар, цаг хугацаа хэмнэсэн
- B. Хүн бүр ухаалаг утас ашиглаж чадахгүй учир зөвхөн бүртгэл үүсгэсэн
- C. Цахим банкныг ашиглахад ахмад настангуудад бэрхшээл тулгарсан
- D. Цахим банк ашиглах хурд, хүч болон харилцаа холбооны мэдээлэл цөөрсөн

20. Эдийн засгийн дундаж өсөлт 3% байгаа энэ үед нэг хүнд ногдох экологийн ул мөр 2,6га, агаарын температур 0.8°C-ээр нэмэгдэж, биологийн төрөл зүйл 30% нь устгах эрсдэлд оржээ. Хэрэв бүх зүйл энэ хэвээрээ үргэлжилбэл 2050 он гэхэд ямар түвшинд хүрэх вэ? Доорх зургийг ашиглан зөв хариултыг сонгоорой.




- A. 4
- B. 3
- C. 2
- D. 1

Эх сурвалж: Global Footprint Network

Дэлхийн экологийн ул мөр
Одоо ба ирээдүй

21. Хүн амын суварга нь залуу, идэр, хөгшин гэсэн 3 үндсэн хэлбэртэй байдаг. Хятад улсын хүн амын суваргын өөрчлөлтийг ажиглан 3 хэлбэрт хамаарах оныг тодорхойлоорой.



- A. Залуу – 2050 он, Идэр – 1990 он, Хөгшин – 2023 он
- B. Залуу – 2050 он, Идэр – 2023 он, Хөгшин – 1990 он
- C. Залуу – 2023 он, Идэр – 1990 он, Хөгшин – 2050 он
- D. Залуу – 1990 он, Идэр – 2023 он, Хөгшин – 2050 он


22. Доорх мэдээллийг ажиглан асуултад хариулаарай.

Дэлхий нийтээрээ 21 дүгээр зуунд хөгжлийн шинэ шатанд гарч, аж үйлдвэрийн дөрөв дүгээр хувьсгалын эрин үед шилжиж эхэлсэн. Аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгал нь өндөр технологийн бүтээгдэхүүн, шинэ ололт, амжилтуудаараа өрсөлдөж буй. Энэхүү өндөр технологийн үндсэн түүхий эд нь газрын ховор элемент юм. Одоогийн байдлаар Монгол оронд Мушгиа худаг, Хотгор, Лугийн гол, Халзанбүрэгтэй ордод улсын төсвөөр болон аж ахуйн нэгжүүд хувийн хөрөнгөөрөө газрын ховор элементийн хайгуулын ажил гүйцэтгэж, нийт 3 сая тн ислийн нөөц тогтоосон.

Монгол улсад өндөр технологийг хөгжүүлэх боломжтой юу, шалтгааныг оновчтой тодорхойлсныг сонгоорой.


- A. Боломжтой, байгалийн баялаг, түүхий эдийн нөөц байгаа учир
- B. Боломжтой, хүмүүсийн ажлын бүтээмж багасаж, эрүүл мэндэд сөрөг учир
- C. Боломжгүй, ажлын байр ихсэж, хүний үйл ажиллагаа өсөх учир
- D. Боломжгүй, байгалийн нөөц түүхий эдийн нөөц түгээмэл учир

23. Гурвалжин диаграммыг ажиглан ажил эрхлэлтийн байдал нь аж үйлдвэрийн салбарт – 23%, үйлчилгээний салбарт – 50%, ХАА-н салбарт 27% ажиллаж буй улс орныг зөв тодорхойлсныг сонгоно уу.




- A. Тайланд
- B. Тайвань
- C. Шри Ланк
- D. Малайз

24. Нэгэн үйлдвэрийн зах зээлийн зургийг ажиглан түүхий эд нь зах зээлд хэрхэн нөлөөлж байгааг дүгнэж бичээрэй.



- A. Тухайн үйлдвэрлэлд олон дамжлага явагдаж хаягдал ихээр ялгарч, зах зээлд нийлүүлэх бүтээгдэхүүний гарц бага..
- B. Тухайн үйлдвэрийн түүхий эдийн боловсруулалт их, зах зээлд нийлүүлэх бүтээгдэхүүний гарц их байна.
- C. Тухайн үйлдвэр түүхий эдийг боловсруулан эцсийн бүтээгдэхүүнээ гаргаж, зах зээлд нийлүүлдэг.
- D. Тухайн үйлдвэрийн түүхий эдээс маш бага хаягдал гарч, дийлэнх нь эцсийн бүтээгдэхүүн болж зах зээлд гарч байна

25. Австрали нь хонины мах экспортоороо дэлхийд тэргүүлэгч томоохон үйлдвэрлэгч орон юм. Зургийг ашиглан Австралийн хонины тоо толгой хамгийн олон байгаа мужийг тодорхойлон, түүнд нөлөөлөх байгалийн хүчин зүйлийг тайлбарлаарай.



- A. Хойд нутагт орших ба өндөрлөг гадаргатай.
- B. Баруун Австралид орших ба хур тунадас элбэгтэй.
- C. Шинэ өмнөд Уэльсд орших ба чийглэг уур амьсгалтай.
- D. Квинслэндэд орших ба гол мөрөн ихтэй.


САНАМЖ

1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул зөв хариултыг олж тогтоож, харгалзах [a] үсгийн дагуу хариуг бөглөөрэй. Жишээлбэл: Зөв хариу 2-ыг сонгосон бол [a] дээр 2-ыг тоог будаж бөглөнө.
2. Хэрэв бодлогын хариу бутархай тоо байвал бодлого тус бүрийн хариултын загварын дагуу бөглөнө. Жишээлбэл: Бодлогын хариу 45.67 гарсан гэж үзвэл тухайн бодлогын хариулт бөглөх загварыг [ab.cd] гэсэн байдлаар өгсөн байна. Дээрх хариуг бөглөхдөө a4 b5 c6 d7 гэж бөглөнө.

ХОЁРДУГААР ХЭСЭГ: ЗАДГАЙ ДААЛГАВАР

- 2.1. Дараах хүн амын тоо, өсөлтийн график болон хүснэгтэн мэдээллийг ашиглан асуултуудад хариулаарай.

| УЛСЫН НЭР | 2023 оны хүн амын тоо (сая) | Хүн амын дундаж өсөлт (хувь) |
|-----------|-----------------------------|------------------------------|
| Энэтхэг | 1,639 | 1.22 |
| БНХАУ | 1,402 | 0.39 |




- Энэтхэг улсын хүн амын өсөлт хэдэн оноос хойш БНХАУ-аас илүү болсон байна вэ? [a]
 1. 2024 он
 2. 2023 он
 3. 2022 он
 4. 2021 он
- БНХАУ-ын хүн амаас Энэтхэг улсын хүн ам илүү болоход нөлөөлсөн хүчин зүйлийг сонгоорой. [b]
 1. БНХАУ 2015 оноос хойш “Хоёр хүүхэд” бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн.
 2. Энэтхэг улсад байгалийн гамшиг, халдварт өвчин тархалт нэмэгдсэн.
 3. БНХАУ-ын улсын бодлого болон Ковид-19 өвчний тархалтад их өртсөн.
 4. Энэтхэг улсын эдийн засаг ДНБ-ны хэмжээ багасаж, халамж багассан.
- 2023 оноос 2050 он гэхэд БНХАУ-ын хүн амын өсөлтийн хэтийн төлөвийг тооцоолоорой. [c,def]

$$P_n = P_0 (1 + (R/100)T)$$

P_n – хэдэн жилийн дараах хүн амын тоо
 P_0 – тухайн жилийн хүн амын тоо
 R – жилийн дундаж өсөлт, хувь
 T – тооцооны хамрах хугацаа (жилийн зөрүү)

2.2. Дараах зураг болон мэдээллийг ашиглан асуултуудад хариулаарай.



Хорватын хамгийн том далайн боомт болох Рижикаг зурагт харуулав. Түүний гол үйл ажиллагаа нь ачаа тээвэрлэх, зохицуулах юм. Хорватын тээвэрт өргөтгөх хэрэгцээ нэмэгдэж маршрут болон үйлчилгээний чанар, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд гол анхаарлаа хандуулж байна.

i. Рижика далайн боомтын тээврийн маршрутын одоогийн онцлогийг тодорхойлоорой. [a]

1. Далайн боомтоос хот болон тосгон, дүүрэг рүү шууд авто замаар холбогдон хурдан шуурхай тээвэрлэлт явагдаж байна.
2. Далайн боомтоос тосгонуудаар заавал дамжиж хот руу авто замын тээвэрлэлт явагдаж байна.
3. Далайн боомтоос бүх тосгон, дүүрэг, хот руу шууд холбогдон тээвэрлэлтийг саадгүй хүргэж байна.
4. Далайн боомтоос зөвхөн хот руу их хэмжээний тээвэрлэлт хийж тосгонууд руу дамжуулалт хийгдэж байна.

ii. Рижика далайн боомтын зураг дахь маршрут нь аль тээврийн төрлийн эдийн засагт чухал ач холбогдолтой байна вэ?

- | | | |
|----------------|-------------------|------------|
| 1. Усан тээвэр | 2. Авто тээвэр | [b] |
| 3. Төмөр зам | 4. Агаарын тээвэр | |

iii. Дээрх Рижика далайн боомтыг өргөтгөх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд хамгийн чухал ач холбогдолтой тээвэрлэлтийн маршрутыг сонгоорой.

Энэ нь их хэмжээний бараа бүтээгдэхүүнийг өртөг багатайгаар тээвэрлэн, үр ашигтай хурдан шуурхай түгээн нийлүүлэхэд зориулсан байх шаардлагатай. **[c]**

